

Гарчиг

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. <i>Төслийн ерөнхий мэдээлэл</i>	3
1.2. <i>Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа</i>	5
1.3. <i>Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц</i>	6
1.4. <i>Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө</i>	6
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	7
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	8
3.1 <i>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж</i>	8
3.3 <i>Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим</i>	11
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	13
4.1. <i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	14
4.2. <i>Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө</i>	17
4.3. <i>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	17
4.4. <i>Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө</i>	17
4.5. <i>Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө</i>	18
4.6. <i>Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь</i>	18
4.7. <i>Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр</i>	19
4.8. <i>Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь</i>	22
4.9. <i>2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал</i>	22

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүд	5
Хүснэгт 2. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	8
Хүснэгт 3. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	10
Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл.....	12
Хүснэгт 5. Гол сөрөг нөлөөлөл.....	12
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	14
Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 8. Эвдэрсэн газар техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө	17
Хүснэгт 9. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний зардал	17
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал.....	18
Хүснэгт 11. Байгаль орчны аудит	Error! Bookmark not defined.
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	19
Хүснэгт 13. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал.....	22

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
--	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Бужгар-2” нэртэй хайлуур жоншны ордын ил уурхайн аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Дорноговийн үйлс” ХХК. Хаяг: Улаанбаатар хот, Баягол дүүрэг, 10-р хороо, Кёкүшю цамхаг, 405 тоот.
Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:	Улаанбаатар хотоос 330.0 км-т, Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлана. Талбайн солбицлууд: 1. 45° 47' 56.63" 109° 10' 41.73" 2. 45° 47' 56.63" 109° 09' 37.74" 3. 45° 48' 13.63" 109° 09' 37.74" 4. 45° 48' 13.63" 109° 10' 41.73"
Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:	Улсын бүртгэлийн гэрчилгээ ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9019057080 ✓ Регистрийн дугаар: 5473748 ✓ Улсад бүртгүүлсэн: 2011.04.25 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл ✓ Дугаар: MV-011931 ✓ Олгосон огноо: 2007.01.29



Төслийн талбайн байршил

Дорноговь аймаг, Айраг сум.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Уурхайн ашиглалтын горим

2024 онд уурхайн хэвийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс доор дурьдсан технологийн шаардлагыг хангаж ажиллана. Доорхи авсан хэмжигдэхүүнүүдийг тусгасан дэвсгэр болон босоо, хөндлөн зүсэлт зургууд дээр ил уурхайн байгуулж ил уурхайн хүрэн дэх уулын цул, хүдэр болон хөрс хуулалтын хэмжээг тодорхойлсон ба зарим нөхцөлд мөргөцөгийн налууугийн хэмжээ нь хүдрийн биетийн уналын өнцөгөөр тодорхойлогдож байгаа.

Хүснэгт 1. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүд

Үзүүлэлт	Нэгж	Тоон үзүүлэлт
Уурхайн амсрын дундаж урт	метр	212
Уурхайн амсрын дундаж өргөн	метр	180
Уурхайн гүн	метр	62
Уурхайн ёроолын дундаж урт	метр	65
Уурхайн ёроолын дундаж өргөн	метр	23
Уурхайн хажуугийн өнцөг	градус	45
Доголын өндөр	метр	5
Доголын хажуугийн өнцөг	градус	60
Аюулгүйн бермийн өргөн	метр	5
Траншейн өргөн	метр	8
Траншейн налуу	промилль	100

Уурхайн хөрс хуулалт

Уулын ажлын төлөвлөгөөний дагуу жилд 100.32 мян.м³ хөрс хуулна. Ил уурхайгаас гарах хөрсний чулуулгийг ил уурхайн урд байрлах хөрсний гадаад овоолгод хураана. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтонд HYUNDAI R520LC-9 экскаватор ажиллана.

Хөрс тээврийн зай хамгийн багадаа ашиглалтын эхний жилд 0.4 км, 2 дах жилд 0.4 км, 3,4 дахь жилд 0.5 км байна. Хөрс тээврийн дундаж зай 0.4 км байна.

Хөрсний түвшинд ажлын доголын өндөр 2.5 м байна HYUNDAI R520LC-9 экскаватор нь тэслэгдсэн нуралд дэд догол үүсгэж 2.5-3 м өндөртэй мөргөцөгт ажиллана. Ажлын талбайн хамгийн бага өргөн 20 м байна. Экскаватор нь хөндлөн орлоор орж ажиллах ба ахилтын хурд 20-30 м/хоног байна. Ажлын талбай бэлтгэх, мөргөцгийн ул түрэх ажилд 1 ширхэг Luigong ZL50CN утгуурт ачигч ажиллана. HYUNDAI R520LC-9 экскаватор HOWO автосамосвалын хослол ажиллахад цагт 407 м³/цаг (700 мян.м³/жил) бүтээлтэй ажиллана.

Тоног төхөөрөмжүүд нь жилд дунджаар 1152 мото-цаг ажиллана. Хөрс тээврийн ажилд тээврийн зайнаас хамаарч HOWO автосамосвал 2-3 ширхэг ажиллана. Автосамосвалын дундаж хурд ачаатай чиглэлд 28 км/цаг, хоосон чиглэлд 32 км/цаг байна. Автосамосвалын рейсийн хугацаа хөрс тээврийн зайнаас хамаарч 400-420 секунд (6-7 минут) байна.

Хүдэр олборлолт

Уурхайгаас жонш олборлолтын ажилд HYUNDAI R520LC-9 экскаватор нь хөрсний мөргөцгөөс хүдрийн мөргөцөгт шилжиж ажиллана. Ажлын доголын өндөр 2.5 м байна. Ажлын талбайн хамгийн бага өргөн 20 м байна. Жилд дунджаар 573 мото/цаг ажиллана. Ажлын талбай бэлтгэх, мөргөцгийн ул түрэх ажилд 1 ширхэг ZL50 утгуурт ачигч ажиллана.

1.3. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.3.1. Уурхайн цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчид ба эрчим хүчний үүсгэвэр

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг УБТЗ-ын Айраг өртөө 2-р хэсэг Ус цахилгаан түгээх сүлжээний 35/10кВт-ын АШ-аас цахилгаан эрчим хүчээр хангана. Цахилгаан эрчим хүчийг Чойрын зүүн өмнөд бүсийн 110кВт-ын цахилгаан түгээх станциас гарган авч буй 0.4 кВ-н 3-н фазын хүчдэлийг 1600 кВА чадалтай ТМН-1600- 0.4/6 төрлийн хоёр трансформаторын тусламжтай 6 кВ - ын хүчдэл болгон өсгөж үйлдвэр, уурхайн бүх цахилгаан хэрэглэгчдийг эрчим хүчээр хангахаар төлөвлөв.

1.3.2. Уурхайн гэрэлтүүлэг

Ил уурхай, хүдэр ялгах хэсэг болон овоолгын цахилгаан гэрэлтүүлэг: Ил уурхай, хүдэр ялгах хэсэг, овоолго нь харьцангуй талбай багатай тул ПКН-1500 маркийн гэрэлтүүлгийн төхөөрөмжийг ашиглахаар сонгон авсан.

Уурхайн цахилгаан хангамжийн систем реле хамгаалалтын шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх ба хамгаалалтын газардуулгын нийт эсэргүүцэл газрын дээр 4 Омоос хэтрэхгүй байна.

1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2024 оны төлөвлөлтөөр 1, 2, 4-р хүдрийн биетүүдэд ил уурхайн аргаар олборлолтын ажил хийж гүйцэтгэх ба 3-р хүдрийн биет олборлолтод өртөхгүй. Харин 1,2,4-р хүдрийн биетэд олборлолт явагдхаар төлөвлөлөө. Ил уурхайгаар 2024 онд 1-р хүдрийн биетээс 10.85 мян.тн, 2-р хүдрийн биетээс 11.00 мян.тн, 4-р хүдрийн биетээс 18.15 мян.тн хүдэр олборлохоор тооцлоо.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжих талбай нь байгалийн бүс бүслүүрийн хувьд говийн бүс ба геоморфологийн мужлалаар Монголын дорнод мужид хамаарна.

Судалгааны талбай орчмын нутгаар хуурай хээрийн амьтад тархсан. Үүнд мэрэгчдээс бозлог, алаг даага, орог зусаг, элсний зусаг, шар чичүүл, атигдаахай зэрэг амьтад элбэг, махчин амьтнаас үнэг, хярс, мануул, өмхий хүрэн, жигүүртнээс тас, элээ, тоодог, харцага, болжмор, ногтруу мөн олон төрлийн шавьжнаас цох, царцаа, хөх түрүү, хар ялаа, хачиг, мухар ялаа элбэг Хөрс ургамлын бүтэц нь өөрийн тархалт, зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, нам дор газарт цайвар шаргал, хужирлаг, толгодын эл хажуугаар хүрэвтэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн, хүрэн бор хөрс нь голдуу элсэнцэр агуулах ба хужирлаг цайвар шаргал хөрс нь аллювиаль, нуурын гаралтай шавар, шавранцараас тогтоно.

Шимт хөрсний үеийн зузаан нь 0,05-0,2м, хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархац маш сийрэг, хонхор хотгор газрууд толгодын хажуу бэл хэсэгт хур борооны дараа газар нь сэргэж ургамлын тархац ихэсдэг. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч нэр төрлийн өвс ургамал нь хягана агь таана, хөмөл, шарилж зэрэг болно. Дов толгодын нуруу хажуу хэсгээр алтан харгана, дэрс цайдам хөндийн хэсэгт бударган, дэрс ургадаг. Нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Ажиглалтаас үзэхэд улирал, сар, хонгийн температур нь эрс хэлбэлздэг, хур тундас бага, хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард -12°C-25°C, хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард +20°C +22°C байдаг. Дулааны улиралд 9 сарыг дуустал үргэлжилдэг. Хур тундас бага унадаг, жилд дунджаар 160-180 мм хүрдэг. Үүний ихэнх хэсэг нь зуны улирлын сүүлч, намрын эхээр бороо ордогтой холбоотой ба өвөлд дунджаар 23-27 мм хур тундас унадаг. Эх газрын баруун хойноос чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2,8-7,3 м.сек хүртэл хурдасч шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Дорноговийн үйлс” ХХК-ийн “Бужгар-2” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 2. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x			x			x		x	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x	
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
Зэрлэг амьтдын орон зай		x		x			x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										x
Бэлчээрийн байдал	x	x			x		x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ				x		x				
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x			x			x		x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										

Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x			x			x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x	x		
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x	x			x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x			x			x
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x			x	x	x			x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x				x
Хүчтэй салхи, уруйн үер	x			x			x			x
Дүн	18	3	0	10	11	4	17	2	13	6

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, дунд зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо *магадлан жагсаах* аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 3. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				

Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			x	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			x	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x		
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				x

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

3.3 Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

“Бужгар-2” нэртэй хайлууур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд хайлууур жоншны хүдрийг олборлох, ухаж ачих, тээвэрлэх, бутлан ангилах, гараар ялгах үйл ажиллагаанууд хийгдэнэ. Ийм ил уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэв. Энэ нөлөөллийн чухал байдлын зэрэглэл ба нөлөөллийн болзошгүй утгыг 1-10 хүртэл оноогоор нилээд дэлгэрэнгүй байдлаар тодорхойлов. Ийнхүү үнэлгээ өгөхдөө аль болохоор бодит байдалд тулгуурласан нарийн мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтийг үндэс болголоо. Леопольдын матрицын арга нь дараах 3 үйлдэл хийхийг шаарддаг. Үүнд:

- ✓ Хэрэв экологийн тогтолцоонд төслийн технологийн үе шатны аль нэг үйл ажиллагаа нь нөлөөлөхөөр байвал түүнд харгалзах дөрвөлжинг ташуу зураасаар 2 хуваана.
- ✓ Хуваагдсан хэсгийн доод талд болзошгүй нөлөөллийн чухал байдлыг 1-10 хүртлэх тоогоор үнэлнэ.

- ✓ Хуваагдсан хэсгийн дээд талд мөн 1-10 хүртлэх оноогоор болзошгүй нөлөөллийн хүчтэй эсэхийг үнэлэн бичнэ. Үүнд: 1 балл бол үнэлгээний хамгийн бага, 10 нь хамгийн их утга юм.

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

№	Үйл ажиллагааны хэлбэр Экологийн тогтолцоо	Хөрс хуулах	Тэсэлгээ	Нүх, карьер ухах	Овоолго	Ачих тээвэрлэх	Бутлан ангилах, гараар ялгах	Бүгд
1	Агаар	2/3	9/9	8/8	3/3	4/5	8/8	34/36
2	Хөрс	2/5	10/10	10/10	6/6	2/3		30/34
3	Гадаргын ус							
4	Газрын доорхи ус							
5	Ургамал	5/5	9/9	9/9	8/8	2/3	6/6	39/40
6	Ан амьтан	1/1	1/1	2/2		1/3	3/3	8/10
7	Усны ургамал							
8	Геологийн тогтоц	1/1	9/9	3/3		1/1		14/14
9	Байгалийн үзэсгэлэн	1/1	5/5	4/4	1/1			11/11
10	Бэлчээр	2/2	5/5	8/8	6/6	1/1	5/5	27/27
11	Хүний эрүүл мэнд	5/6	4/5	5/6	1/2		9/9	24/28
12	Бүгд	19/24	52/53	49/50	25/26	11/16	31/31	187/200

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүх, карьер ухах, овоолго хийх, ачих тээвэрлэх явц нь агаар, хөрс, ургамал, хүний эрүүл мэнд зэрэгт ихээхэн нөлөөлж болзошгүй нь харагдаж байна.

Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал зэрэг юм.

Нөлөөлөлд орох байдлаар ангилбал агаар 34/36, ургамал 39/40, хөрс 30/34, бэлчээр 27/27, хүний эрүүл мэнд 24/28 1-р ангилалд, геологийн тогтоц 14/14, 2-р ангилалд орж байна. Иймд 1 ба 2-р ангиллын өртөгчдөд нарийвчилсан судалгаа, тооцоо хийх нь зүйтэй.

Хүснэгт 5. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.
2	Агаар	Хайлуур жоншны хүдрийг ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх, уурхайд тэсэлгээ хийх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт хэрэгжих “Бужгар-2” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” –ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Дорноговийн үйлс” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас 2020 онд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арилгах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаар				
✚ Уурхай орчимд тоосжилт үүсэх	<ul style="list-style-type: none"> ✚ Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах ✚ Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх ✚ Авто машины тусгай зориулалттай зогсоолтой байх ✚ Уурхайн замыг зөвхөн нэг маршрутаар явуулах 	Үйл ажиллагааны турш	1000.0	<ul style="list-style-type: none"> ✚ Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот сууриын газрын агаарын чанарыг хянах журам: MNS 17.2.3.16 - 1988 ✚ Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 3384 - 1982
✚ Тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны явцад агаар орчинд хорт хийн ялгарал үүснэ.	<ul style="list-style-type: none"> ✚ Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх 	Авто машины тээвэр хийх үед	500.0	<ul style="list-style-type: none"> ✚ MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт ✚ MNS 5013:2003 Бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 ✚ Дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
Газрын гадарга, хэвлий				
✚ Уурхай дахь хайлуур жоншийг олборлож, газрын гадаргад цоо шинэ хотгор гүдгэрийн хэлбэр үүсгэнэ.	<ul style="list-style-type: none"> ✚ Карьерын хананд хэвгийгүйжилт хийж гулсалт нуралтгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг хангах байдлаар техникийн нөхөн сэргээлт хийх 	Тухай бүрт	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар	<ul style="list-style-type: none"> ✚ MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” ✚ MNS 5917:2008

				<p>“Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд</p> <p>✚ Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам</p>
Ургамал ба амьтан				
<p>✚ Уурхайгаас барилгын элс олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.</p>	<p>✚ Эвдрэлд, доройлтолд ороогүй газруудад машин техникүүдийг явуулахгүй байх</p> <p>✚ Хаягдал чулуулгийн овоолго, хаягдал хадгалах байгууламжийн дээр ургамлан нөмрөгийг нөхөн сэргээх</p> <p>✚ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээд уурхайн тосгон орчимд мод тарьж зурвас үүсгэх /Дэвсгэр зурагт тариалах талбайн хэмжээг төлөвлөсөн болно./</p>	<p>Шимт хөрс хуулалтын үед, зам, карьер болон бусад газрын ашиглалт дууссаны дараа</p>	<p>Нөхөн сэргээлтийн зардлаар</p>	<p>MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.</p>
<p>✚ Автомашины хөдөлгөөн, овоолго, зэрэг төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт нь ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлж, ургамал устах нөхцлийг бий болгох</p>	<p>✚ Тоосжилтоос үүсэх дам нөлөөг багасгах үүднээс шаардлагагүй замуудыг хаах, усалгаа хийх, байнгын хяналт тавьж байх</p> <p>✚ Ургамлын мониторинг хийлгэх</p>	<p>2 жилд 1 удаа</p>	<p>1 500.0</p>	
<p>✚ Төслийн болон ойр орчмын нутаг дэвсгэр дэх уурхайн болон дэд бүтцийн үйл ажиллагаа, ашиглалттай холбоотойгоор амьтны аймаг үргэж дүрвэх</p>	<p>✚ Мэргэжлийн байгууллагатай хамтран амьтны аймгийн урт хугацааны мониторинг явуулах</p>	<p>Жил бүр</p>	<p>1 500.0</p>	
Хөрсөн бүрхэвч				
<p>Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон,</p>	<p>Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах</p>	<p>Тухай бүрт</p>	<p>Нөхөн сэргээлтийн зардлаар</p>	<p>✚ Газрын төлөв байдал, чанарын хяналт баталгаа явуулах журам, мөн</p>

бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	<ul style="list-style-type: none"> Хэлбэржүүлж зассан талбайг шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлтгэх 			<ul style="list-style-type: none"> УСТ 12-156-91 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
<ul style="list-style-type: none"> Ил уурхайн, овоолгууд, хаягдал болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох 	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны явцад ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг нэгдсэн нэг цэгт төвлөрүүлэн түр хадгалж, орон нутгаас зааж өгсөн цэгт тогтсон хугацаанд зайлуулж байх шаардлагатай 	Тухай бүрт нь	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	
	<ul style="list-style-type: none"> Эвдэрсэн замыг хусаж тэгшлэх, зам дээр асгарсан шороо, чулууг түрж зайлуулах 	Тухай бүрт	Нөхөн сэргээлтийн зардлаар	
<ul style="list-style-type: none"> Хог хаягдлаар хөрс бохирдож болзошгүй 	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлыг, тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ариутгах, зайлуулах арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хийх 	Тухай бүрт	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	
	<ul style="list-style-type: none"> Эко “ОО” суурилуулах 	2024 онд	1000.0	
Ус				
<ul style="list-style-type: none"> Ус бохирдоход ажиллагсад, ойр хавийн хүн, мал, ан амьтан өртөх эрсдэлтэй 	<ul style="list-style-type: none"> Ажилчид болон орон нутгийн иргэд ахуйн усанд ашиглахаар төлөвлөж буй болон ашиглаж байгаа худаг, ил задгай уснаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг тодорхойлох Хөрсний усанд бохирдол шингэхээс сэргийлэх, техник тоног төхөөрөмжийг зөв зохистой ашиглах, хог хаягдлыг зайлуулах менежментийг сайжруулах Ахуйн бохир усыг ус, хөрс бохирдуулахгүй цооногт хуримтлуулан ариун цэврийн байгууллагаас тогтоосон цэгт зайлуулж байх, дахин боловсруулж үйлдвэрт ашиглах технологийг хэрэглэх 	Жил бүр	ОХШХ-ийн зардлаас	
Нийт			5 500.0	

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн тосгон орчимд мод тарих	ш	100	10.0	1 000.0 /Үйл ажиллагааны зардлаар/	2024 онд	
2	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-
Нийт						1 000.0		

4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Эвдэрсэн газар техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт хийх	“Яшил” нэртэй талбайд орхигдсон 3.1 га талбайг нөхөн сэргээх	7 500.0 /Үйл ажиллагааны Зардлаас/	2024 онд

4.4. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний зардал

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	--*--
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	500.0
Ажиллагсдыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	500.0
Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангах	1 000.0
Нийт зардал	2 000.0

4.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, ангилан ялгах үйлдвэрийн талбай, кемп орчимд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах	250.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Нийт		250.0	

4.6. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2024 онд төлөвлөөгүй болно.

4.7. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Эхний 1 жилийн зардал (мян.төг/жил)	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшин
1	<p>Агаарын чанар Агаар дахь тоосжилт PM_{2.5}, PM₁₀</p> <p>Агаарын найрлага SO₂, NO₂, CO, Pb</p>		<p>✚ Уурхайн карьерын зонхилох салхины доод талаас</p> <p>✚ Тээвэрлэлт хийх зам орчмын зонхилох салхины доод талаас</p>	Жилд 1 удаа	2	100.0	200.0	<p>MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага</p> <p>MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага</p> <p>MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга</p> <p>MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга</p> <p>MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга</p> <p>MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны</p>	<p>PM_{2.5}- 50 мкг/м³ 24 цаг, 25 мкг/м³ жил</p> <p>PM₁₀- 100 мкг/м³ 24 цаг, 50 мкг/м³ жил</p> <p>SO₂-20 мкг/м³ 24 цаг, 10 мкг/м³ жил</p> <p>NO₂-40 мкг/м³ 24 цаг, 30 мкг/м³ жил</p> <p>CO-30000мкг/м³ 1 цаг, 1000 мкг/м³ 8 цаг</p> <p>Pb-1 мкг/м³ 24 цаг, 0.5 мкг/м³ жил</p>

								зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга	
2	<p>Хөрсний усны хяналт шинжилгээ: Усны чанар: PH, уусан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг NH₄-N, NO₂-N, NO₃-N, PO₄-P, Cl, F, SO₄, Mn, Ni, Cu, Mo, Cd, Co, Pb, As, Cr, Cr⁶⁺, Zn, Hg, Эрдэс тос, фенол, ГИНБ, Benzo(a) pyren</p>		Төсөл ашиглагдах гүний худгаас	Жилд 1 удаа	1	45.0	45.0	<p>MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO)5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт</p>	<p>PH-6.5-8.5, NH₄-N 0.5 мгN/л, NO₂-N 0.2 мгN/л, NO₃-N 9.0 мгN/л, PO₄-P 0.1 мгP/л, Cl 300мг/л, F 1.5 мг/л, SO₄ 100мг/л, Mn 0.1 мг/л, Ni 0.01 мг/л, Cu 0.01 мг/л, Mo 0.25, Cd 0.005 мг/л, Co 0.01 мг/л, Pb 0.01 мг/л, As 0.01 мг/л, Cr 0.05 мг/л, Cr⁶⁺ 0.01 мг/л, Zn 0.01 мг/л, Hg 0.1 мг/л, Эрдэс тос 0.05 мг/л, фенол 0.001 мг/л, ГИНБ 0.1 мг/л, Benzo(a) pyren 0.005 мкг/л</p>
3	<p>Хөрсний бохирдол: Нүүрстөрөгчийн нэгдлүүд буюу нефтийн бүтээгдэхүүн: Тиофенол, фенол, бензол, хөдөлгүүрийн тос хар тугалга</p>		<p>✚ Автозамын ойр орчмоос ✚ Тээвэрлэлт хийх зам орчмын зонхилох салхины доод талаас</p>	Жилд 1 удаа	2	55.0	110.0	<p>MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS(ISO) 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын</p>	<p>Хар тугалга (Pb) 100, Кадмий (Cd) 3, Мөнгөн ус (Hg) 2, Мишьяк (As) 6, Хром (Cr) 150, Зургаан валентат хром (Cr⁶⁺) 4, Цагаан тугалга (Sn) 50, Стронций (Sr) 800, Ванаций (V) 150, Зэс (Cu) 100, Никель (Ni) 150, Кобальт (Co) 50, Цайр (Zn) 300, Молибден (Mo) 5, Селен (Se) 10, Бор (B) 25, Фтор (F) 200, Цианид (Cn) 25 мг/л, Тиофенол, фенол 4, газрын тосны бүтээгдэхүүн 2 мг/кг</p>

								хэмжээг тодорхойлох лабораторын арга	
4	Ургамлан нөмрөг: Ургамлан нөмрөгийн маршрутын судалгааны бичиглэлд заасан үзүүлэлтүүд, Монгол Улсын улаан номонд орсон, нэн ховор, эндемик болон реликт ургамлууд		Төслийн үйл ажиллагаагаар эвдрэлд өртөх газрууд болон түүний ойр орчмын Монгол Улсын улаан номонд орсон нэн ховор, эндемик болон реликт ургамлуудын бичиглэл хийх	Төслийн хэрэгжилтийн туршид жилд 1 удаа (7 сард)	1	200.0	200.0	Ургамлан нөмрөгийн маршрутын судалгааны бичиглэл	МУШУА Ботаникийн хүрээлэн ургамлын судалгааны аргазүй
5	Амьтны аймаг: Зэрлэг амьтдыг тоолох бүртгэх, популяци, нүүдэл, зүйлийн бүрдлийг судлах		Төсөл хэрэгжиж буй газар	Нүүдлийн хугацаанд жилд 1 удаа 4-5 дугаар сард	1	200.0	200.0	Зэрлэг амьтдын судалгааны хээрийн бичиглэл хийх зааварчилгаа, Биологийн хүрээлэн 1992, Хээрийн бичиглэлийн асуулга	МУШУА Биологийн хүрээлэн зэрлэг амьтдын популяцийн анхан шатны мэдээлэл цуглуулах аргазүй
Үйл ажиллагаа явуулах үед 1 жилд хийх байгаль орчны хяналтын шинжилгээний ажлын нийт зардлын дүн					755.0				

**4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг
нөлөөлдө өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

Хүснэгт 12. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	250.0 мян.төг
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	250.0 мян.төг

4.9. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 17.505 сая төгрөг төлөвлөж
өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 5.5 сая.төг,
дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалд 7.5 сая төгрөг, осол, эрсдэл, удирдлага
зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд 2.0 сая.төг, хог хаягдал
менежментийн төлөвлөгөөнд 250 мян.төг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 755
мян.төг, олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардалд 500.0 мян.төг, “Тэрбум
мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд 1.0 сая төгрөг зарцуулахаар тооцсон болно.